БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022. 03. 24 № 312

танай _____ны № _____т

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Ц.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Төрийн аудитын газраас танай байгууллагын 2022 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийсэн дүгнэлт, тайланг хүргүүлж байна.

Аудитаар 16.6 сая төгрөгийн 3 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор бүрэн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана уу.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.ЭРДЭНЭ

006030376

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/196/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.open.audit.mn Булган аймаг 2023 он	Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Г.Цэрэнлхам Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenlkhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 3
Асуудлыг онцолсон хэсэг 3
Аудитын гол асуудал 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 8
3.4.1 Мөнгөн хөрөнгө 10
3.5.2 Авлага 10
3.5.3 Урьдчилгаа 11
3.5.4 Бараа материал 11
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө 11
3.5.6 Үндсэн хөрөнгө 11
3.5.7 Өр төлбөр 12
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо 12
4. АУДИТЫН ТАЙЛАН 14
4.1 Ерөнхий зүйл 14
4.2 Материаллаг байдал 15
4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 15
4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 15
4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 15
4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 16
4.7.1 Завсрын аудитын талаар 16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 16
5.1 Төлбөрийн акт 16
5.2 Албан шаардлага 16
5.3 Зөвлөмж 17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ 18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		9,852,697.40	8,593,217.70
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	6,748,891.60	6,264,970.10
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	3,086,936.80	2,312,301.20
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	16,869.00	15,946.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,139,531.10	1,150,658.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,139,531.10	1,150,658.70
39200	Биет хөрөнгө		1,130,612.00	1,143,710.90
39300	Биет бус хөрөнгө	13	8,919.00	6,947.90
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		10,992,228.50	9,743,876.40
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		228,125.70	209,461.70
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	228,125.70	209,461.70
41300	Өглөг	17а, 17б	51,987.10	47,490.90
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	176,138.60	161,970.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		10,764,102.80	9,534,414.70
51	Засгийн газрын хувь оролцоо		10,764,102.80	9,534,414.70
51100	Засгийн газрын оруулсан капитал		181,679.90	181,679.90
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		181,679.90	181,679.90
51200	Хуримтлагдсан үр дүн		10,579,716.70	9,350,028.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		2,706.20	2,706.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		10,992,228.50	9,743,876.40

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		107,919,649.30	79,869,511.90
11	ТАТВАРЫН ОРЛОГО		22,752,357.90	21,269,379.40
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		22,752,357.90	21,269,379.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	53,420.30	82,617.20
120	Нийтлэг татварын бус орлого		53,420.30	82,617.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		85,113,871.00	58,517,515.30
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	106,799,134.10	81,092,991.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ		106,799,134.10	81,092,991.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		653,571.20	668,410.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		441,955.70	466,516.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		58,024.80	58,553.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		32,685.30	42,734.50
2104	Хангамж, бараа материалын зардал		22,883.90	19,568.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		7,623.10	2,314.00

2107	Томилолт, зочны зардал		634.00	4,058.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		24,140.00	10,672.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		65,624.40	63,992.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		106,145,562.90	80,424,580.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,120,515.20	(1,223,479.40)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		9,563.00	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		1,130,078.20	(1,223,479.40)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		107,533,391.10	80,712,423.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО		22,102,822.50	21,203,994.80
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		22,102,822.50	21,203,994.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		303,628.60	154,349.40
120	Нийтлэг татварын бус орлого		303,628.60	154,349.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		85,126,940.00	59,354,079.20
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		106,936,238.70	81,196,345.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ		106,936,238.70	81,196,345.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		588,595.80	604,377.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		441,956.70	466,516.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		58,024.80	58,553.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		32,685.30	42,734.50
2104	Хангамж, бараа материалын зардал		23,959.40	18,648.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		7,623.10	2,314.00
2107	Томилолт, зочны зардал		634.00	4,058.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		21,694.20	9,668.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,018.30	1,883.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		106,347,642.90	80,591,968.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		597,152.30	(483,921.50)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		597,152.30	(483,921.50)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		6,151,739.30	6,748,891.60
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		6,748,891.60	6,264,970.10

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,611,996.60	9,611,996.60

2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	22,028.00	22,028.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,634,024.60	9,634,024.60
9	Тайлант үеийн үр дүн	1,130,078.20	1,130,078.20
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,764,102.80	10,764,102.80
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	10,764,102.80	10,764,102.80
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(6,208.70)	(6,208.70)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,757,894.10	10,757,894.10
19	Тайлант үеийн үр дүн	(1,223,479.40)	(1,223,479.40)
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	9,534,414.70	9,534,414.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**72,762,246.70**	**72,371,001.00**	**391,245.70**	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	72,762,246.70	72,371,001.00	391,245.70	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	635,973.50	604,377.03	31,596.47	95.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	489,573.90	466,516.67	23,057.23	95.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,139.00	58,553.90	2,585.10	95.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,001.00	42,734.52	266.48	99.4
2104	Хангамж, бараа материалын зардал	19,071.10	18,648.62	422.48	97.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,355.40	2,314.05	41.35	98.2
2107	Томилолт, зочны зардал	4,060.20	4,058.10	2.10	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,789.60	9,668.16	5,121.44	65.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,983.30	1,883.00	100.30	94.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,126,273.20	71,766,623.97	359,649.23	99.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,126,273.20	71,766,623.97	359,649.23	99.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	72,762,246.70	26,569,122.04	46,193,124.66	36.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,034,353.80	9,034,353.80	-	100.0
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	63,727,892.90	17,501,682.86	46,226,210.04	27.5
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	79	77	2	97.5
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	39	38	1	97.4
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	39	38	1	97.4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансыг ашиглаагүй болно.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгмийн даатгалын хэлтэс нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйл, Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааг явуулдаг НДЕГ-ын харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий ДААТГАГЧ болох" хэтийн зорилготой, "Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ" гэж эрхэм зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгынхоо хүрээнд дараах үйл ажиллагааны стратеги зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах,
- Нийгмийн даатгалын санг бүрдүүлэх, орлого зарлагын гүйцэтгэлийг хангах,
- Нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах,
- Улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх,
- Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг хүрээнд,

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоол,
- Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль,
- "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол, "Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 2022 оны 192 дугаар тогтоол, 194 дүгээр тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд бусад эрх бүхий байгууллагаас болон хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Харин дотоод хяналт аудитын тасаг нь 2022 онд хэлтсийн даргын баталсан ажлын төлөвлөгөөний дагуу ажил олгогч болон сайн дурын даатгалын илүү төлсөн шимтгэл, нийгмийн даатгалын сангийн бусад өглөг, авлагын барагдуулалт, залруулгын гүйцэтгэлийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн даатгалын хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьяр хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/64 дүгээр тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 10,992.2 сая төгрөг болж, өмнөх оноос 9,743.8 сая төгрөгөөр буюу 11.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,748.89	6,264.97	(483.92)
Авлага	3,086.93	2,312.30	(774.63)
Бараа материал	16.87	15.95	(0.92)
Үндсэн хөрөнгө	1,139.53	1,150.65	11.12
Нийт хөрөнгө	**10,992.22**	**9,743.87**	**(1,248.35)**
Өр төлбөр	51.98	47.49	(4.49)
Урьдчилж орсон орлого	176.14	161.97	(14.17)
Засгийн газрын хувь оролцоо	10,764.10	9,534.41	(1,229.69)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	**10,992.22**	**9,743.87**	**(1,248.35)**

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны оны эхний үлдэгдэл 9,852.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 8,593.2 сая төгрөг болж, 1,259.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл *(сая төгрөгөөр)*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	0.26	14.28	(14.02)	0.2
Арилжааны банк дахь харилцах	6,748.29	6,250.53	(497.76)	99.8
Бусад төсөл, нөөцийн харилцах	-	0.15	0.15	0.0
Замд яваа мөнгөн хөрөнгө	0.34	-	(0.34)	-
Дүн	**6,748.89**	**6,264.97**	**(483.92)**	**100.00**

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 6,264.8 сая төгрөг буюу 99.9 хувийг нийгмийн даатгалын сан, 0.1 сая төгрөг буюу 0.1 хувийг нийгмийн даатгалын хэлтэс эзэлж байна.

Сангийн хөрөнгийн хөрөнгийн үлдэгдэл нь арилжааны 3 банкинд байршиж байгаа бөгөөд нийт үлдэгдлийн 4,176.2 сая төгрөг буюу 66.6 хувь нь ХААН банкинд, 14.3 сая төгрөг буюу 0.2 хувь нь Төрийн банкинд, 2,074.3 сая төгрөг буюу 33.1 хувь нь Төрийн сан банкинд тус тус байршиж байна.

3.4.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалтын данс үлдэгдэлгүй байна.

3.4.3 Авлага

Авлага дансны оны эхний үлдэгдэл 3,086.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2,312.3 сая төгрөг болж, 774.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3. Авлагын дансны үлдэгдэл *(сая төгрөгөөр)*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төлбөртэй үйлчилгээний авлага	633.15	768.15	135.00	33.2
Татаас, санхүүжилтийн авлага	2,390.42	1,496.83	(893.59)	64.7
Байгууллагаас авах авлага	63.37	47.32	(16.05)	2.1
Дүн	**3,086.93**	**2,312.30**	**(774.64)**	**100.0**

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 2,312.1 сая төгрөг буюу 99.9 хувийг нийгмийн даатгалын сан, 0.2 сая төгрөг буюу 0.1 хувийг нийгмийн даатгалын хэлтэс эзэлж байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн 0.2 сая төгрөгийн авах эзэнгүй болсон 2005 оноос хойш үүссэн авлага байна. Төлбөртэй үйлчилгээний авлагад аж ахуй нэгж байгууллагын шимтгэлийн авлага, татаас санхүүжилтийн авлагад НДШ-ийн чөлөөлөлт, ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон дэмжлэг, бусад авлагад тэтгэврийн даатгалын санд тавигдсан улсын байцаагчийн акт, тэтгэмжийн илүү олголт, сан хоорондын ташаарсан авлагууд байна.

Аудитын илрүүлэлт:

Нийгмийн даатгалын хэлтсийн 0.2 сая төгрөгийн авах эзэнгүй болсон 2005 оноос хойш үүссэн авлагыг бууруулах арга хэмжээ зохион байгуулж ажиллаагүй байна.

3.4.4 Урьдчилгаа

Урьдчилгаа данс үлдэгдэлгүй байна.

3.4.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс үлдэгдэлгүй байна.

3.4.6 Бараа материал

Бараа материал дансны оны эхний үлдэгдэл 16.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 15.9 сая төгрөг болж, 0.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4. Бараа материал дансны үлдэгдэл *(сая төгрөгөөр)*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Бичиг хэргийн материал	1.61	1.33	(0.2)	8.3
Аж ахуйн материал	12.85	12.85	-	80.7
Түлш, шатах тослох материал	1.55	0.90	(0.65)	5.6
Бусад хангамжийн материал	0.85	0.85	-	5.4
Дүн	**16.86**	**15.93**	**(0.93)**	**100.0**

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийгмийн даатгалын хэлтэс тайлант онд төсвийн хөрөнгөөр 3.8 сая төгрөгийн бичиг хэргийн материал, 2.4 сая төгрөгийн аж ахуйн материал, 1.4 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 9.1 сая төгрөгийн түлш шатах тослох материал бэлтгэж, НДЕГ-аас 1.0 сая төгрөгийн үнэт цаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна.

Аудитын илрүүлэлт:

Тайлант онд бэлтгэсэн 16.6 сая төгрөгийн бараа материалыг орлогод авч, зарцуулахдаа Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын хамтарсан 2002 оны 171/111 дугаар тушаалаар батлагдсан хүчин төгөлдөр бус анхан шатны баримтыг ашигласан байна.

3.4.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны оны эхний үлдэгдэл 1,139.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,150.6 сая төгрөг болж, 11.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл *(сая төгрөгөөр)*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Барилга, байгууламж, орон сууц	1,102.04	1,102.04	-	95.8
Хуримтлагдсан элэгдэл	(62.53)	(93.53)	(30.99)	(8.1)
Авто-тээврийн хэрэгсэл	89.98	13.49	(76.48)	1.2
Хуримтлагдсан элэгдэл	(89.98)	-	89.98	-
Машин тоног төхөөрөмж (компьютер)	132.47	145.19	12.71	12.6
Хуримтлагдсан элэгдэл	(75.47)	(48.61)	26.85	(4.2)
Тавилга, аж ахуйн эд хогшил	88.55	83.63	(4.92)	7.3
Хуримтлагдсан элэгдэл	(54.45)	(58.50)	(4.04)	(5.1)
Программ хангамж	2.19	2.19	-	-
Хуримтлагдсан элэгдэл	(0.24)	(2.22)	(1.97)	(0.2)
Бусад биет бус хөрөнгө	6.97	6.97	-	-
Дүн	**1,139.53**	**1,150.65**	**11.12**	**100.0**

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас НДЕГ-ын даргын 2022 оны А/159, А/194 дүгээр тушаалаар 56.0 сая төгрөгийн 59 нэр төрлийн тоног төхөөрөмжийг шилжүүлэн авсан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын "Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай" 2022 оны 521 дүгээр тогтоол, НДЕГ-ын даргын 2022 оны А/184, 193 дугаар тушаалаар тус тус үндэслэн 32.2 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж, 109.8 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын үнийг шинэчлэн тогтоож орлогодож авсан байна.

3.4.8 Өр төлбөр

Өр төлбөр дансны оны эхний үлдэгдэл 228.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 209.4 сая төгрөг болж, 18.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл *(сая төгрөгөөр)*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	0.13	0.13	-	0.1
Бараа үйлчилгээний зардлын өглөг	51.27	46.77	(4.49)	22.3
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	0.57	0.57	-	0.2
Байгууллагад төлөх өглөг	0.12	0.12	-	0.1
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	176.13	161.97	(14.16)	77.3
Дүн	**228.12**	**209.46**	**(18.66)**	**100.00**

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өглөгийн үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 208.7 сая төгрөг буюу 99.7 хувийг нийгмийн даатгалын сан, 0.7 сая төгрөг буюу 0.3 хувийг нийгмийн даатгалын хэлтэс эзэлж байна.

Тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн өглөг 1.8 сая төгрөгөөр өссөн, Урьдчилж төлөгдсөн шимтгэлийн орлого 14.2 сая, бусад өглөг 6,.4 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Тайлант онд өглөгийг хувь хүн байгууллага тус бүрээр шалгаж, хүсэлт шийдвэрлэх ажлыг зохион байгуулан ажилласан боловч НДХ-ийн үйл ажиллагаанд 0.7 сая төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй 2005 оноос хойш үүссэн өглөг бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Нийгмийн даатгалын хэлтсийн 0.7 сая төгрөгийн эзэнгүй болсон 2005 оноос хойш үүссэн өглөгийг бууруулах арга хэмжээ зохион байгуулж ажиллаагүй байна.

3.4.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 10,764.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 9,534.4 сая төгрөг болж, 1,229.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №7. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл *(сая төгрөгөөр)*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	181.67	181.67	-	1.9
Хуримтлагдсан үр дүн	10,579.71	9,350.02	(1.22)	98.1

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2.70	2.70	-	0.0
Дүн	**10,764.10**	**9,534.41**	**(1,229.68)**	**100.00**

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнг 1,223.5 сая төгрөгөөр хүлээн зөвшөөрч, НББ-ийн өөрчлөлт дансанд 6.2 сая төгрөгийн бичилт хийгдсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Нийгмийн даатгалын сангийн орлогыг 170,461.3 сая, зарлагыг 58,754.2 сая төгрөгөөр тооцож, 111,707.1 сая төгрөгийн зөрүүтэйгээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хууль, 2022 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд оруулсан өөрчлөлт, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны "2022 оны төсвийн хуваарь батлах тухай" 23 дугаар тогтоол, 2022 оны 02 дугаар тогтоол, 05 дугаар тогтоолоор баталсан аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын болон нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2022 оны төсвийн хуваариар орлогыг 152,811.6 сая, зарлагыг 5,992.0 сая төгрөгөөр бууруулж, орлогыг 17,649.7 сая, зарлагыг 52,762.2 сая төгрөгөөр баталсан байна.

Төсөвт тодотгол Засгийн газрын "Тэтгэврийн хэмжээ нэмэгдүүлэх тухай" 2022 оны 63 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар, Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээг 500.000 (таван зуун мянган) төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 400.000 (дөрвөн зуун мянган) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор хийгдсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Нийгмийн даатгалын сангийн нийт орлогын гүйцэтгэл 26,562.2 сая төгрөг буюу 99.5 хувьтай, зарлагын гүйцэтгэл 72,371.0 сая төгрөг буюу 99.5 хувьтай байна.

НДСангийн орлого, зарлагын гүйцэтгэл. *(сая төгрөгөөр)*

Сангийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Сангийн нийт орлогын дүн	***26,690.97***	***26,562.21***	***128.76***	***99.5***
Тэтгэвэрийн даатгал	23,774.36	23,767.84	6.52	100.0
Тэтгэмжийн даатгал	1,464.36	1,532.51	(68.15)	104.7
ҮОМШӨ-ний даатгал	1,188.44	982.07	206.37	82.6
Ажилгүйдлын даатгал	263.81	279.79	(15.98)	106.1
Сангийн нийт зарлагын дүн	***72,762.22***	***72,371.00***	***391.22***	***99.5***
Тэтгэвэрийн даатгалын сан	69,182.74	68,907.63	275.11	99.6
Тэтгэмжийн даатгалын сан	1,881.71	1,855.82	25.89	98.6
ҮОМШӨ-ний даатгалын сан	355.66	316.35	39.31	88.9
Ажилгүйдлын даатгалын сан	681.19	660.73	20.46	97.0

Үйл ажиллагааны зардал	660.92	630.47	30.45	95.4

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлсэн үйл ажиллагааны зардал 630.5 сая төгрөг буюу 95.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл *(сая төгрөгөөр)*

д/д	Хөтөлбөр арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	код	нэр				
1	71901	Нийгмийн даатгал	654,008.20	623,562.60	30,445.60	95.3
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	594,796.70	574,347.60	20,449.10	96.6
1.2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	11,340.00	5,102.27	6,237.73	44.9
1.3	80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	2,666.70	2,417.60	249.10	90.7
1.4	80213	Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн хөрөнгийн зардал	400.00	6.00	394.00	1.5
1.5	80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	12,924.30	10,163.15	2,761.15	78.6
1.6	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	21,666.40	21,666.40	-	100.0
1.7	80813	Хуульд заасан үндэслэлээр албаны зардал	2,300.00	2,300.00	-	100.0
1.8	80820	Бусад тусламж, дэмжлэг	7,914.10	7,559.58	354.52	95.5
1.9	81549	Ахмадын сан	-	-	-	-

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "*Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана*" гэж заасны дагуу Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагаа, бүртгэл тайлагналыг сайжруулах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 1-2/55 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвөөс 72,762.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,091.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 818.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайланд онд МУИХ-аас төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сард баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллагыг Төрийн аудитын байгууллага байхаар хуульчилсан.

Үүний дагуу "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл"-ийг МУЕА-ын 2022 оны А/59 дүгээр тушаалаар, "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар"-ыг МУЕА-ын 2022 оны А/89 дүгээр тушаалаар баталж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийж ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь зардлын үр ашгийг сайжруулах, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, төсөв хэмнэх, төсвийн сахилга батыг чангатгах арга хэмжээг авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 265 мэдээлэл мэдээлэхээс 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 1-2/276 дугаар албан тоотоор ирүүлсэн.

Хүснэгт 9. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	0.12	1	0.12	100.0
Албан шаардлага	3	6.41	3	6.41	100.0
Зөвлөмж	7	4.23	7	4.23	100.0
Нийт дүн	**11**	**10.75**	**11**	**10.75**	**100.0**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар эрүүл мэндийн даатгалын сангийн орлого бүрдүүлсэн байцаагч нарын урамшуулал, эзэн холбогдогч нь тодорхойгүй болсон өглөг, авлагыг бууруулахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 99.5 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 99.5 сая төгрөгийн 1 алдааг залруулсан. Үүнд:

- Санхүүгийн тайлан тусгагдсан дүрмийн сан (Засгийн газрын оруулсан капитал)-ийн үлдэгдэл, улсын бүртгэлийн гэрчилгээний дүрмийн санд өөрчлөлтийг хийлгэж зөрүүг арилгасан.

Аудитаар нийт 16.6 сая төгрөгийн 3 зөрчил[2] илэрснээс, 16.6 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд бэлтгэсэн 16.6 сая төгрөгийн бараа материалыг орлогод авч, зарцуулахдаа хүчин төгөлдөр бус анхан шатны баримтыг ашигласан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Сангийн сайдын баталсан 2017 оны 347 дугаар тушаал, 2018 оны 100 дугаар тушаалыг тус тус хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Сангийн сайдын баталсан 2017 оны 347 дугаар тушаал, 2018 оны 100 дугаар тушаал хэрэгжүүлэн ажиллах.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн системд 265 мэдээлэл байршуулахаас 16 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 -д заасныг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргах байх албан шаардлага өгөх.

3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төрийн өмчид бүртгэлтэй 69-89БУЛ улсын дугаартай авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т *"Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ"* үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн	Too	Дүн

НДСан	1	99.5	-	-	1	99.5	1	99.5	-	-	-	-
НДХ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	**1**	**99.5**	**-**	**-**	**1**	**99.5**	**1**	**99.5**	**1**	**-**	**-**	**-**

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

Байгуулагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
НДСан												
НДХ	1	16.6					1	16.6				
Дүн	**1**	**16.6**					**1**	**16.6**				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
НДСан	1	-					1	
НДХ								
Дүн	**1**	**-**					**1**	**-**
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
НДСан								
НДХ	1	-					1	-
Дүн	**1**	**-**					**1**	**-**
Нийт дүн	**2**	**-**			**-**	**-**	**2**	**-**